

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2024/159/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Долгорсүрэн Утас: 51-261628 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn Ахлах аудитор: О.Баярмаа Утас:51-261628 Цахим хаяг: bayarmaao@audit.gov.mn Аудитор: Ж.Бүжинханд Утас:51-261628 Цахим хаяг: bujinlkhandj@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ
ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ч.АМАРБАЯСГАЛАН
ТАНАА

2024.02.23 № 07/271
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны нэмэлт санхүүжилтээр гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хөтөлбөрийн хүрээнд НҮБ-ын хүн амын сангаас 494,615.1 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож төлөвлөгөөний дагуу зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант хугацаанд 21 аймгийн ИТХ-ын дарга, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга нартай “Хамтын ажиллагааны гэрээ” байгуулан, 568 хамтарсан баг тус бүрд 300.0 мянган төгрөгийн нийт 170,400.0 мянган төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж олгосон байна.

Мөн Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлэгч 16 байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай 362,530.5 мянган төгрөгийн үнэ бүхий бараа материал, тоног төхөөрөмжийг худалдан авч, хүлээлгэн өгсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант онд 4 зорилтын хүрээнд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг 94.2 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	146,789,459.00	357,673,455.05
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	69,140,066.00	34,271,677.00
31100	Кассад байгаа бэлэн мөнгө	-	-
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	69,140,066.00	34,271,677.00
31210	Төгрөг	69,140,066.00	34,271,677.00
31211	Төрийн сангийн харилцах	69,140,066.00	34,271,677.00
34	УРЬДЧИЛГАА	14,129,580.00	0
34600	Урьдчилж гарсан зардал	14,129,580.00	0
35	БАРАА МАТЕРИАЛ	63,519,813.00	323,401,778.05
35100	Түүхий эд материал	255,900.00	255,900.00
35130	Эм боох материал	255,900.00	255,900.00
35400	Хангамжийн материал	63,263,913.00	323,145,878.05
35410	Бичиг хэргийн материал	2,409,938.00	2,085,703.05
35420	Аж ахуйн материал	94,000.00	75,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,250,000.00	0
35470	Бусад хангамжийн материал	59,509,975.00	320,985,175.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	79,040,435.71	124,599,975.26
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	79,040,435.71	124,599,975.26
39200	Биет хөрөнгө	78,527,102.31	92,899,975.26
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	115,661,835.51	159,795,471.87
39206	Хуримтлагдсан элэгдэл	(40,149,923.44)	(69,575,874.01)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,348,130.00	3,348,130.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(332,939.76)	(667,752.60)
39300	Биет бус хөрөнгө	513,333.40	31,700,000.00
39301	Программ хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(366,666.60)	(880,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	-	31,700,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	225,829,894.71	482,273,430.31
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	69,140,066.00	34,271,677.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	69,140,066.00	34,271,677.00
41400	Урьдчилж орсон орлого	69,140,066.00	34,271,677.00
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	69,140,066.00	34,271,677.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	156,689,828.71	448,001,753.31
51	Засгийн газрын хувь оролцоо	156,689,828.71	448,001,753.31
51200	Хуримтлагдсан үр дүн	156,689,828.71	448,001,753.31
51210	Өмнөх үеийн үр дүн	147,538,842.93	156,689,828.71
51220	Тайлант үеийн үр дүн	9,150,985.78	291,311,924.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	225,829,894.71	482,273,430.31

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,221,201,559.00	2,121,726,538.07
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	987,026.00	9,378,636.36
120	Нийтлэг татварын бус орлого	987,026.00	9,378,636.36
120009	Бусад орлого	945,000.00	665,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	8,713,636.36
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	42,026.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,220,214,533.00	2,112,347,901.71
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,709,691,900.00	1,591,483,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,709,691,900.00	1,591,483,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	510,522,633.00	520,864,101.71
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	510,522,633.00	520,864,101.71
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,435,361,753.22	1,454,304,113.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,435,361,753.22	1,454,304,113.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,416,593,770.23	1,439,621,536.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	238,079,635.00	354,101,065.89
210101	Үндсэн цалин	147,683,684.80	200,158,096.29
210102	Нэмэгдэл	50,339,732.20	76,998,786.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,460,000.00	46,004,859.71
210104	Урамшуулал	17,596,218.00	30,939,323.63
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,087,182.61	30,771,883.77
210201	Тэтгэврийн даатгал	14,448,487.31	19,390,137.05
210202	Тэтгэмжийн даатгал	1,699,821.99	2,281,192.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,336,337.55	1,824,954.09
210204	Ажилгүйдлийн даатгал	289,253.40	432,359.42
210205	Эрүүл мэндийн даатгал	4,313,282.36	6,843,240.60
2104	Хангамж, бараа материалын зардал	22,198,983.40	13,091,054.67
210401	Бичиг хэрэг	5,734,722.00	4,269,155.00
210402	Тээвэр, шатахуун	8,764,000.00	4,635,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,096,699.40	2,611,999.67
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,603,562.00	1,574,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	666,600.00	112,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	666,600.00	112,300.00
2107	Томилолт, зочны зардал	1,579,000.00	773,900.00
210702	Дотоод албан томилолт	1,579,000.00	773,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,104,605,747.00	1,010,157,234.95
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,102,846,747.00	1,004,869,234.95
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,759,000.00	5,288,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,376,622.22	30,614,096.81
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	720,000.00	340,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,656,622.22	30,274,096.81
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,767,982.99	14,682,577.38
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,390,847.00	3,303,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,390,847.00	3,303,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,377,135.99	11,379,577.38
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,377,135.99	11,379,485.67
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	91.71
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	785,839,805.78	667,422,424.60
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	776,688,820.00	376,110,500.00

225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	776,688,820.00	376,110,500.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	9,150,985.78	291,311,924.60

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,257,337,144.00	2,136,435,256.71
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	37,122,611.00	24,087,355.00
120	Нийтлэг татварын бус орлого	37,122,611.00	24,087,355.00
120009	Бусад орлого	37,122,611.00	24,087,355.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,220,214,533.00	2,112,347,901.71
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,709,691,900.00	1,591,483,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,709,691,900.00	1,591,483,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	510,522,633.00	520,864,101.71
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	510,522,633.00	520,864,101.71
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,203,183,903.00	2,103,518,645.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,203,183,903.00	2,103,518,645.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,184,415,920.01	2,088,836,068.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	238,079,635.00	354,101,065.89
210101	Үндсэн цалин	147,683,684.80	200,158,096.29
210102	Нэмэгдэл	50,339,732.20	76,998,786.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,460,000.00	46,004,859.71
210104	Урамшуулал	17,596,218.00	30,939,323.63
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,087,182.61	30,771,883.77
210201	Тэтгэврийн даатгал	14,448,487.31	19,390,137.05
210202	Тэтгэмжийн даатгал	1,699,821.99	2,281,192.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,336,337.55	1,824,954.09
210204	Ажилгүйдлийн даатгал	289,253.40	432,359.42
210205	Эрүүл мэндийн даатгал	4,313,282.36	6,843,240.60
2104	Хангамж, бараа материалын зардал	16,054,099.40	9,015,499.67
210401	Бичиг хэрэг	2,273,000.00	1,114,000.00
210402	Тээвэр, шатахуун	6,258,000.00	3,120,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,096,699.40	2,611,999.67
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,426,400.00	2,169,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,927,070.00	1,078,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,927,070.00	1,078,300.00
2107	Томилолт, зочны зардал	1,579,000.00	773,900.00
210702	Дотоод албан томилолт	1,579,000.00	773,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,895,915,733.00	1,692,755,419.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,894,156,733.00	1,687,467,419.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,759,000.00	5,288,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	773,200.00	340,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	773,200.00	340,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,767,982.99	14,682,577.38
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,390,847.00	3,303,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,390,847.00	3,303,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,377,135.99	11,379,577.38
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,377,135.99	11,379,485.67
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	54,153,241.00	32,916,611.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	21,820,130.00	67,120,000.00

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	21,820,130.00	67,120,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	21,820,130.00	67,120,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	21,820,130.00	67,120,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(21,820,130.00)	(67,120,000.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	(665,000.00)
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	665,000.00
250006	Бусад зардал	-	665,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	32,333,111.00	(34,868,389.00)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	36,806,955.00	69,140,066.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	69,140,066.00	34,271,677.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	147,538,842.93	147,538,842.93
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	147,538,842.93	147,538,842.93
3	Тайлант үеийн үр дүн	-	-	9,150,985.78	9,150,985.78
4	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	156,689,828.71	156,689,828.71
5	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	156,689,828.71	156,689,828.71
6	Тайлант үеийн үр дүн	-	-	291,311,924.60	291,311,924.60
7	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	-	448,001,753.31	448,001,753.31

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,591,487,400.00	1,580,104,314.33	11,383,085.67	99.3
УРСГАЛ ЗАРДАЛ	1,591,487,400.00	1,580,104,314.33	11,383,085.67	99.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,588,143,100.00	1,576,801,314.33	11,341,785.67	99.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	354,106,900.00	354,101,065.89	5,834.11	100.0
Үндсэн цалин	217,029,800.00	200,158,096.29	16,871,703.71	92.2
Нэмэгдэл	76,215,300.00	76,998,786.26	(783,486.26)	101.0
Унаа хоолны хөнгөлөлт	26,460,000.00	46,004,859.71	(19,544,859.71)	173.9
Урамшуулал	34,401,800.00	30,939,323.63	3,462,476.37	89.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,763,500.00	30,771,883.77	10,991,616.23	73.7
Тэтгэврийн даатгал	28,399,100.00	19,390,137.05	9,008,962.95	68.3
Тэтгэмжийн даатгал	3,341,000.00	2,281,192.61	1,059,807.39	68.3
ҮОМШӨ-ний даатгал	2,672,800.00	1,824,954.09	847,845.91	68.3
Ажилгүйдлийн даатгал	668,300.00	432,359.42	235,940.58	64.7
Эрүүл мэндийн даатгал	6,682,300.00	6,843,240.60	(160,940.60)	102.4
Хангамж, бараа материалын зардал	9,015,500.00	9,015,499.67	0.33	100.0
Бичиг хэрэг	1,114,000.00	1,114,000.00	-	100.0
Тээвэр, шатахуун	3,120,000.00	3,120,000.00	-	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,612,000.00	2,611,999.67	0.33	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,169,500.00	2,169,500.00	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	36,498,300.00	36,498,300.00	-	100.0
Багаж, техник, хэрэгсэл	36,498,300.00	36,498,300.00	-	100.0
Томилолт, зочны зардал	773,900.00	773,900.00	-	100.0
Дотоод албан томилолт	773,900.00	773,900.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,145,606,100.00	1,145,300,665.00	305,435.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,140,318,100.00	1,140,012,665.00	305,435.00	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,288,000.00	5,288,000.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	378,900.00	340,000.00	38,900.00	89.7
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	378,900.00	340,000.00	38,900.00	89.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,344,300.00	3,303,000.00	41,300.00	98.8
Бусад урсгал шилжүүлэг	3,344,300.00	3,303,000.00	41,300.00	98.8
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,344,300.00	3,303,000.00	41,300.00	98.8
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,591,487,400.00	1,580,104,314.33	11,383,085.67	99.3
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,591,487,400.00	1,580,104,314.33	11,383,085.67	99.3

Улсын төсвөөс санхүүжих	1,591,487,400.00	1,580,104,314.33	11,383,085.67	99.3
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	
Төсвийн байгууллага	1	1	-	
АЖИЛЧДЫН ТОО	15	13	(2)	
Удирдах ажилтан	1	1	-	
Гүйцэтгэх ажилтан	14	12	(2)	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		520,864,101.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ		520,864,101.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		520,864,101.71
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		520,864,010.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		520,864,010.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		91.71
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		91.71
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		91.71
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		520,864,101.71
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		520,864,101.71
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		520,864,101.71

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 86.8 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 1.8 сая төгрөгийн төлбөрийн 1 акт тогтоож, 14.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага хүргүүлж, 70.0 сая төгрөгийн 6 зөвлөмж өгсөн.

Аудитаар алдаа² илрээгүй.

Үүнээс санхүүгийн тайлангийн аудитын нийт 16.7 сая төгрөгийн зөрчил³ илэрснээс, 1.8 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 14.9 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөрөнгийн биет тооллогоор 3 нэр төрлийн 18 ширхэг 1,826.6 мянган төгрөгийн бараа материал дутагдсан.	1	1826.6	1	1,826.6				
Албан томилолтын хуудсанд явсан чиглэл, очсон, ирсэн огноог тэмдэглээгүй, томилолтыг олгох эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүй, ажилласан хугацааг буруу тэмдэглэсэн томилолтын хуудсаар 14,957.0 мянган төгрөгийн томилолтыг олгосон.	1	14,957.0			1	14,957.0		
Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн машин тоног төхөөрөмж 16,450.9 мянган төгрөг, программ хангамж 880.0 мянган төгрөг нийт 17,330.9 мянган төгрөгийн үнэ бүхий 9 нэр төрлийн 16 ширхэг хөрөнгө байна.	1	-					1	-
Дүн	3	16,783.6	1	1,826.6	1	14,957.0	1	-

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 70.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 70.0 сая төгрөгийн 5 зөвлөмж өгсөн.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим мэдээллийн сангийн “Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл” цэст Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх, Тойм судалгаа хийх, Гэр бүл хүчирхийллийн хохирогчдод үзүүлсэн үйлчилгээний чанар, хүртээмж, хүчирхийлэгч этгээдийг хүчирхийллийн харилцаанаас татгалзуулах чиглэлээр хийсэн ажлын үр дүнгийн судалгаа хийх 70,000.0 мянган төгрөгийн зөвлөх үйлчилгээний худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг байршуулаагүй байна.	1	70,000.0					1	70,000.0
Дүн	1	70,000.0					1	70,000.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.	1	-					1	-
Няравыг томилсон тушаал шийдвэргүй, байгууллагын эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулаагүй байна.	1	-					1	-
Байгууллагын албан хаагчид тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын шаардлагыг тодорхойлсон албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, Төрийн албаны зөвлөлөөр батлуулаагүй байна.	1	-					1	-
Байгууллагын 1 авто тээврийн хэрэгсэл нь бусад тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугааргүй	1	-					1	-
Дүн	4	-					4	-
Нийт дүн	5	70,000.0					5	70,000.0